

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. *Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-тэй хамтран хэрэгжүүлж буй “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийн нэгж нь Барилгын эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр мэдлэг олгох, чадавх бэхжүүлэх* зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалтад мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Дэлгэрэнгүй жагсаалтад доорх материалуудыг ирүүлсэн хуулийн этгээдүүдээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16-р зүйлийн шаардлагыг хангасан этгээдүүдийг зөвлөхийн хураангуй жагсаалтад оруулна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь *Барилгын эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр мэдлэг олгох, чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах* болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Цахим татварын тодорхойлолт
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт
- Харилцагч банкнуудын хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн үлдэгдэлгүй талаарх тодорхойлолт
- 2018 оны санхүүгийн тайлангийн хуулбарыг ирүүлнэ.
- Сүүлийн 3 жилийн /2016, 2017, 2018 он/ хугацаанд барилгын эрчим хүчний хэмнэлт, барилгын эрчим хүчний менежер, барилгын эрчим хүчний аудиторын сургалт хийж байсан туршлагатай байна. Ижил төстэй зөвлөх үйлчилгээний талаарх мэдээлэл, жагсаалт ирүүлнэ.
- Зөвлөх үйлчилгээг 5-аас цөөнгүй багшийн бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэнэ. Голлох мэргэжилтнүүдийн иргэний үнэмлэх болон диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, чадвар туршлагын талаарх мэдээллийг ирүүлнэ.
- Сургалт болон дадлагын зориулалтаар ашиглах барилгын дулаан алдагдал, барилгын битүүмжлэл, барилгын дотор агаарын үзүүлэлт, цахилгаан хөдөлгүүрийн чадлын үзүүлэлт, халаалт агаар сэлгэлт кондиционерийн төхөөрөмжийн үзүүлэлт, барилгын гэрэлтүүлэг зэргийг тодорхойлох багаж тоног төхөөрөмжтэй байна.
- Сургалт эсвэл дадлагын газарт халаалтын системийн загвар, агаар сэлгэлтийн системийн загвар, кондиционерийн системийн загвар туршилтын тоноглолуудтай байна.

Голлох мэргэжилтэнд тавигдах чадварын шалгуурын доод үзүүлэлт

№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжил, боловсрол	Ажилласан жил	Туршлага
1	Сургалт явуулах багш, мэргэжилтнүүд	5	Архитектор Барилгын бүтээц Барилгын менежмент/эдийн засаг ХАСК Барилгын цахилгаан хангамж Дулаан хангамж Автоматжуулалт зэрэг мэргэжилтэй	10 болон түүнээс дээш жил	Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байна.
2		3	Нэмэлт чадвар: Барилгын эрчим хүчний чиглэлээр мэргэшсэн, сургалтын байгууллагуудад хичээл зааж байсан туршлагатай, Эрчим хүчний газраас эрчим хүчний аудитор, менежерүүдийн хичээл заах эрхийн гэрчилгээтэй байна.	10 болон түүнээс дээш жил	Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байна.

4. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд болон сургалтын байгууллагууд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 12 цаг 00 минутаас өмнө** авч болох бөгөөд материалаа дор дурдсан хаягаар **2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** ирүүлнэ үү.

6. 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн зарын дагуу дэлгэрэнгүй жагсаалтад мэдүүлгээ ирүүлсэн хуулийн этгээд зөвхөн тендер шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг ирүүлэх бөгөөд уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох энэхүү зарын 3-т заасан мэдээллийг дахин ирүүлэх шаардлагагүй болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

“Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл”

Монгол улс, Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,

Засгийн газрын 12-р байр, 4 давхар, 405 тоот

Утас: 7555-2043-(2), 88078527